*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт*

# АРВАЙХЭЭР СУМЫН ЗҮЛЭГТ 12 ДУГААР БАГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАГЧ РЭНЧИНСЭНГИЙН ЭНХ-АМГАЛАНГИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

**Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Гүйцэтгэлийн түвшин | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Суурь түвшин | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин (биелэлт) | Эхэлсэн, дууссан хугацаа | Биелэлт ийн хувь |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| **Зорилт 1. “Хууль тогтоомж, бодлого шийдвэрийг анхан шатанд хэрэгжүүлж, иргэд олон нийтэд сурталчлан ажиллах”** | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ 1.1.Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх, иргэдэд хууль эрх зүйн сургалт, зөвлөгөө өгөх *(АТТодорхойлолт 1.1 дэх заалт)* | Зөвлөгөө, мэдээлэл өгсөн хүний тоогоор | 600 | 700 916 | Иргэдийн хэрэгцээ шаардлагад тулгуурлан аливаа төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд иргэдийн эрх зүйн мэдлэг, ойлголтыг дээшлүүлэхээр гэмт хэрэг, зөрчилд холбогдсон болон холбогдох эрсдэлтэй мөн багийн ажлын албаар үйлчлүүлсэн иргэд, зохион байгуулсан танхимын сургалтад хамрагдсан иргэд, Зүлэгт 12 дугаар багийн эрх зүйн сургалт, сурталчилгааны төлөвлөгөөнд тусгагдсан 4 зорилтын хүрээнд 18 хууль, тогтоомжийн тодорхой зүйл заалтын агуулгаар, түүнчлэн Үндсэн хууль, эрүүгийн хууль, зөрчлийн тухай хууль, захиргааны тухай хууль, иргэний тухай хууль болон бусад хууль тогтоомж, дүрэм, журмын холбогдох зүйл заалтын агуулгаар нийт 916 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан. Зөвлөгөө, мэдээллийг ангилбал: | 2025.01.02-2025.11.28 | 100 ✓ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт тодорхойлолт авсан 20 иргэнд, нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийн талаар 15 иргэнд, Өвөрхангай аймаг дахь иргэний хэргийн анхан шатны шүүхэд холбон зуучлах 16, шилжилт, хаягийн хөдөлгөөнтэй холбоотой 52, хорих ангиас суллагдсан 1, Цагдаагийн газарт тодорхойлолт авсан 34 иргэн, Цэргийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйл. Тайван цагт хугацаат цэргийн албанд татахаас чөлөөлөх 1, 33 дугаар зүйл. Цэргийн бэлтгэл албаны сургалтад хамрагдах 2, 34 дүгээр зүйл. Цэргийн бүртгэлд хамрагдах 18-50 насны 292 иргэн, 12 дугаар зүйл. Хугацаат цэргийн албанд татах тухай 58, сургуульд элсэн суралцах тухай 22, Өмчлөлийн 0.7га газар авах 1, Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай шинэчлэгдсэн журмыг 11 иргэнд, болон 4 удаагийн танхимын сургалтаар 391 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.<br>Хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх "Хуульчийн про боно-2025" өдөрлөгт төрийн болон хууль сахиулах 13 байгууллага оролцож, өдөрлөгөөр иргэдэд анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгөх, төрийн байгууллагын зарим үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэх, иргэдийн гомдол, мэдээллийг хүлээн авах зэрэг хуулийн байгууллагуудын үйл ажиллагаанд иргэдийг идэвхтэй хамруулан ажилласан. Нийт 916 иргэнд зөвлөгөө, мэдээллийг Хууль тогтоомжийн бүртгэл лавламжийн санд байгаа эрх зүйн акт болон Эрх зүй мэдээллийн нэгдсэн системээс лавлагаа | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэдээлэл өгч ажилласны үр дүнд иргэдийн эрх зүйн анхан шатны мэдлэг нэмэгдсэн. | | |
| | | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалтыг танхимаар болон цахимаар зохион байгуулсан тоогоор | 4 | 4 | Иргэдэд хууль тогтоомжийг сурталчлах, бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжин ажиллах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 4 удаагийн танхимын сургалтыг зохион байгуулж, сургалтад 391 иргэн хамрагдсан. Үүнд:<br>1.2025.04.11-ний өдөр цахим орчин дахь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг иргэд олон нийтэд таниулах, түүнчлэн ахмад настнууд эдийн засгийн болон гэр бүлийн хүчирхийлэлд өртдөг тухай, түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх чиглэлээр Хэсгийн байцаагч, дэслэгч Н.Лхагвасүрэн, Багийн цагдаа, ахлагч Ц.Эрдэнэсугар нартай хамтран Арвайхээр сумын Хуралдааны танхимд “Хууль ба амьдрал” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулж, багийн 20 иргэн, 15 хэсгийн ахлагч нийт 35 иргэн хамрагдсан. 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдөр тус багт түр оршин суугч иргэний тухай ирсэн үл таних хүн миний хаан банкны дансыг ашиглан цалингийн зээл авсан гэх мөрдөгчийн мэдэгдэлд үндэслэн тус сургалтыг зохион байгуулж, сургалтын үр дүнд цахим орчин дахь залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар иргэдийн мэдлэг, эрх зүйн ойлголт дээшлэхийн зэрэгцээ багийн хэсгийн ахлагчид хариуцсан хэсгийн иргэдэд мэдээлэл түгээж, ахин дээрх төрлийн гэмт хэрэг, зөрчил бүртгэгдээгүй. | | 100 ✓ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | 2.2025 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан "Хайр түгээе-Инээд бэлэглэе" арга хэмжээний хүрээнд эцэг, эх, хүүхэд багачуудын дунд гэр бүлийн хүчирхийлэл, гэр бүлийн гишүүдийн харилцан ойлголцол, хүүхэд ба эцэг, эхийн эрх үүрэг, хүлээх хариуцлагын талаар Арвайхээр сумын улсын тэргүүний 3-р цэцэрлэгийн эрхлэгч С.Оюунчимэг багштай хамтран "Гэр бүлийн үнэ цэнэ" сэдвээр танхимын сургалт, зохион байгуулж, тус нөлөөллийн арга хэмжээнд багийн 53 хүүхэд эцэг, эх, асран хамгаалагчдын хамт оролцсон. Сургалтын үр дүнд гэр бүл бол нийгмийн хамгийн чухал үнэт зүйл гэдгийг хүүхэд бүрийн сэтгэлд шингээж, хамтдаа өнгөрүүлэх цаг хугацааны үнэ цэнийг ухааруулах, эцэг, эхийн үүрэг хариуцлага болон хүүхдийн эрх, үүрэг, хүүхэд хамгааллын тухай хуулийн ойлголттой болж, эцэг, эх, хүүхдийн хамтын оролцоог нэмэгдүүлсэн зэрэг сэтгэгдэл төрүүлсэн сургалт болсон.<br>3.2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Олон Улсын "Охидын эрхийг хамгаалах" өдрийг тохиолдуулан Согоот 1 дүгээр баг, Бурхи 9 дүгээр баг, Зүлэгт 12 дугаар багийн ажлын алба хамтран охидын эрүүл мэндийн боловсрол, аюулгүй байдал, эрхийг хамгаалах мэдлэгийг нэмэгдүүлэх, охидын өөртөө итгэх итгэл, манлайллыг дэмжих, тэдэнд тулгамдаж буй асуудлыг хэлэлцүүлгээр гаргаж хариу арга хэмжээ авч ажиллах зорилгоор "PINK DAY" арга хэмжээг зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээнд хамран сургах тойргийн Ерөнхий | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Боловсролын 4 дүгээр сургуулийн 6-8 дугаар ангийн 200 орчим охид идэвхтэй оролцсон. Тус арга хэмжээний хүрээнд:<br>-Уян сэтгэл өрхийн эрүүл мэндийн төвийн Нөхөн үржихүй эмэгтэйчүүд болон эх барих хариуцсан Эмч Б.Амаржаргал “Нөхөн үржихүй болон сарын тэмдэг”;<br>-багийн Цагдаа Мянганбаяр “ Хорт зуршил, түүний үр дагавар”;<br>-ЕБ-ын 4 дүгээр сургуулийн Нийгмийн ажилтан Э.Оюунцэцэг “Охидын өнгийг сэтгэл зүйгээр тодорхойлох нь”;<br>-Улсын тэргүүний 3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч С.Оюунчимэг “Мэргэжил сонголт түүний ач тус, амьдралын туршлагаа хуваалцах нь” зэрэг агуулгаар хүрээнд сургалтыг зохион байгуулсан. Тус өдөрлөгт оролцсон охидын эрхийн талаарх мэдлэг дээшилсэн ба сургуулийн орчинд охидын эрхийг дэмжсэн зэрэг хандлага төлөвших, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх болон мэргэжил сонголтын талаарх ойлголт нэмэгдэж, охидын дуу хоолойг сонсох орчин бүрдүүлснээр эргэх холбоотой ажиллахаар болсон зэрэг үр дүнтэй арга хэмжээ болсон.<br>4.2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр Зүлэгт 12 дугаар багийн ажлын албанаас санаачлан Өвөрхангай аймаг дахь Цагдаагийн газар болон Өвөрхангай аймаг дахь Политехник коллеж, Хүүхэд гэр бүл хөгжил хамгааллын газартай хамтран политехник коллежийн 1 дүгээр дамжааны суралцагчдын хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн талаарх ойлголтыг гүнзгийрүүлж, хариуцлагатай иргэн болгон төлөвшүүлэх, өөрийгөө болон | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бусдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг, чадвартай болгох, сургуулийн орчинд аюулгүй, ээрэг, хариуцлагатай харилцааг төлөвшүүлэх зорилгоор "Хууль-Миний хамгаалалт" сэдэвт нөлөөллийн сургалтыг Өвөрхангай аймаг дахь Политехник коллежийн урлаг зааланд зохион байгуулсан. "Хууль-Миний хамгаалалт" нөлөөллийн сургалтад Өвөрхангай аймгийн Политехникийн коллежийн нэгдүгээр дамжааны 103 суралцагчид хамрагдсан. Тус сургалтын хүрээнд хамтарсан багийн үүрэг оролцоо түүнтэй холбогдох мэдээллийн тухай гарын авлага бэлтгэн нэгдүгээр дамжааны 103 оюутнуудад түгээсэн. Сургалтын үр дүнд Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулийн үндсэн ойлголт, насанд хүрээгүйчүүдийн хариуцлагын талаарх хууль эрх зүйн мэдлэг дээшилж, түгээмэл тохиолддог зөрчил, гэмт хэргийн хэлбэрүүдийг таньж, хэрхэн сэргийлэх мэдлэг ойлголттой болохын зэрэгцээ ёс зүйтэй, хариуцлагатай, хамт олонч хандлагыг төлөвшүүлж, сөрөг нөлөөллөөс ангид байх, ээрэг харилцаа, хариуцлагатай зан төлөв төлөвшихөд нөлөөлсөн байна. Бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад иргэдийг идэвхтэй оролцуулсан. Үүнд: -Өвөрхангай аймгийн ХГБХХГазраас "Зөв дадал-Эрүүл ирээдүй" сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, Зүлэгт 12 дугаар багаас 6 иргэн хамрагдсан.<br>-Өвөрхангай аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газраас зохион байгуулсан "Эрүүл нийгмийн бүтээхүйд- | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эрчүүдийн оролцоо" өдөрлөгт багийн 3 эрэгтэй оролцсон.<br>-2025.04.14-ны өдөр Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн аюулгүй байдлыг хангах, согтуугаар үйлдэгдэж байгаа гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх иргэдийн архи, согтууруулах ундааны хэрэглээг багасгах, татгалзах дадлыг бий болгох үүднээс Арвайхээр сумын ЗДТГ, 13 багийн ажлын алба хамтран сургалт зохион байгуулж, архины хамааралтай 1 иргэн хамрагдсан.<br>-2025.10.08-ны өдөр Арвайхээр сумын ЗДТГазраас "Эрчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээ зохион байгуулагдаж, зорилтот бүлгийн 1, гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 1, архины хамааралтай 3, нийт 5 иргэнийг хамруулсан.<br>-Арвайхээр сумын ахмадын хороо ахмадуудад "Ахмад настны тухай хууль"-ийн талаар сургалт зохион байгуулсан. Тус ахмад настны тухай хуулийн нэмэлт өөрчлөлт, журмуудыг танилцуулсан сургалтад багийн 13 ахмад оролцсон.<br>-Төрийн цахим үйлчилгээний хэлтэс, Арвайхээр сумын ахмадын хороотой хамтран "Цахим ур чадварыг сайжруулах" сургалт зохион байгуулсан. Ахмадуудад мэдээллийн технологийн чиглэлээр И-Монголиа-д нэвтрэх, үйлчилгээ авах, банкны аппликэйшн ашиглаж үйлчилгээ авах, тоон гарын үсэг ашиглах зэрэг мэдээллийг өгч ахмадуудын цахим хэрэглээний чадавхыг дээшлүүлсэн арга хэмжээ болсон. Мөн Насан туршийн | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | суралцахуйн төв болон Цагдаагийн газраас Гэгээрсэн буурлууд, Кибер гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтыг зохион байгуулж,сургалтад 2 ахмад оролцсон.<br>-"Ахмад настны тухай хууль"-ийг хэрэгжүүлэх ажлын чиглэл, хөдөлмөр эрхлэлтийн талаар Аймгийн ахмадын хорооны дарга Д.Баяртогтох, ХХҮГ-ын мэргэжилтэн Н.Батням нар танхим болон цахим хосолсон хэлбэрээр сумдын ахмадын хороодын дарга, ААН байгууллагын ахмадын зөвлөлийн дарга, Арвайхээр сумын 13 багийн ахмадын зөвлөлийн дарга нарт хурал, мэдээлэл хийсэн сургалтад багийн ахмадын дарга хамрагдсан.<br>-Аймгийн ахмадын хорооноос шинээр тэтгэвэрт гарсан ахмадуудаа хүлээн авч "Зөвийг үлгэрлэж-манлайлъя" сэдэвт уулзалт зохион байгуулсан. Ахмад настны ая тухтай орчинд чөлөөт цагаа өнгөрөөх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, амьдралын эерэг зан үйл, зөв хэвшилд суралцахад ахмад-залуу үеэ үлгэрлэн манлайлах, ахмад настны хуулийн шинэчлэлтийг сурталчлан таниулах зорилготой, тус сургалтад багийн 4 ахмад оролцсон.<br>- Дэлхийн зөн Олон улсын байгууллагаас зохион байгуулсан"Гал түймрээс өөрийгөө хэрхэн хамгаалах вэ? " Сургалтад 16 хүүхэд хамрагдсан.<br>-Өвөрхангай аймгийн Онцгой байдлын газраас зохион байгуулсан "Монгол хүн ба эрсдлийн боловсрол" аяны нээлт, сургалтад багийн 20 иргэнийг оролцуулсан. | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | -Арвайхээр хотын Захирагчийн албанаас санаачлан Арвайхээр сумын хог хаягдлын менежментийг сайжруулах, хог хаягдлын хор хөнөөл, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлсэн бөгөөд 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр Арвайхээр сумын хог хаягдлын менежментийг сайжруулах ажлын хүрээнд баг тус бүрд хог хаягдлыг чиглүүлэгч бэлтгэх сертификаттай "Хог хаягдлын менежментийг сайжруулах" сэдэвт сургалт нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж Зүлэгт 12 дугаар багийн 2 хэсгийн ахлагч хамрагдсан.<br>-Арвайхээр хотын Захирагчийн албанаас санаачлан 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдөр "Монгол орноо хоггүй болгоё" сэдэвт сургалтыг зохион байгуулсан ба сургалтын зорилго нь иргэдэд хогоо ангилан ялгах, хог бага гаргах амьдралын хэв маягт суралцах, байгальд ээлтэй иргэн төлөвшүүлэх арга технологийн талаар мэдлэг, ойлголт өгөх юм. Тус сургалтад Зүлэгт 12 дугаар багийн 5 иргэн оролцож, хогоо ангилан ялгах, хог хаягдлыг багасгах, хог бага гаргах амьдралын хэв маягт суралцах, байгальд ээлтэй иргэн төлөвшүүлэх ойлголттой болсон.<br>- Мобиком төвөөс зохион байгуулсан Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад багийн 16 ахмад хамрагдсан.<br>- Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эрх ашиг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор явуулын үйлчилгээг хэсэгчилсэн хэлбэрээр Арвайхээр сумын ЗДТГазар, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Өвөрхангай аймгийн Цагдаагийн газар, Уян сэтгэл өрхийн эмнэлэг хамтран зохион байгуулсан. Тус явуулын үйлчилгээ нь аймгийн төв бараан зах, Өндөр гэгээн Занабазарын цэцэрлэгт хүрээлэн, Энх тал худалдааны төв гэсэн 3 газар төвлөрөн ажилласан. Явуулын үйлчилгээнд 60 гаруй иргэн хамрагдаж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал, согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулиуд болон архины хор хөнөөл, гэр бүлийн харилцаа, зөрөг хандлага, хүүхдийг хүмүүжүүлэх зөрөг арга, насанд хүрээгүй хүүхдүүд утаат тамхи худалдаалахгүй байх, хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх чиглэлээр постер, мэдээ мэдээлэл гарын авлагыг бэлтгэн иргэдэд 10 төрлийн 150 гаруй боршур тараасан.<br>Бусад байгууллагаас зохион байгуулсан иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилготой 13 удаагийн сургалтад 89 иргэн хамрагдаж эрх зүйн мэдлэг, ойлголтоо нэмэгдүүлсэн.<br>Цагдаагийн газраас ирүүлсэн мөрдөгчийн мэдэгдлийн хүрээнд Зүлэгт 12 дугаар багийн ажлын албанаас санаачлан эрх зүйн 4 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, нийт 391 иргэн хамрагдсанаар өөрийгөө болон бусдыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх эрх зүйн мэдлэг, ойлголттой болсон үр дүнтэй байна. | | |
| | | Иргэдийн эрх зүйн мэдлэгийг | | 4-өөс доошгүй | Арвайхээр сумын Зүлэгт 12 дугаар багийн 2025 оны эрх зүйн сургалт, сурталчилгааны | | 100 ✓ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дээшлүүлэх зорилгоор 2 ба түүнээс дээш нэр төрлийн хуулийн сургалт сурталчилгаа, гарын авлага, бэлтгэн боловсруулсан тоогоор | 4 | материал бэлтгэж, 400-аас доошгүй иргэнд түгээсэн байна | ажлын төлөвлөгөөг 4 зорилтын хүрээнд 18 арга хэмжээг хийж хэрэгжүүлэхээр боловсруулж, хэрэгжилтийг ханган ажилласны үр дүнд биелэлт 100 хувьтай байна. Тус төлөвлөгөөний дагуу Монгол Улсын Үндсэн хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль сурталчилгаа, Хууль зүйн туслалцааны тухай хууль, Батлан хамгаалах хууль, Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хог хаягдлын тухай хууль Кибер аюулгүй байдлын тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хууль, Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль Малчны тухай хууль, Жижиг дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих хууль Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль Байгаль орчныг хамгаалах тухай хууль Хүүхэд хамгааллын тухай хууль Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, “Халуун ам бүл”, “Хайрлагдсан хүүхэд” төслийн тухай зэрэг нийт 18 хууль тогтоомжийн зүйл заалтын агуулгаар 18 постер буюу гарын авлага, сурталчилгааны материал бэлтгэн боловсруулж, гэмт хэрэг зөрчилд холбогдсон болон холбогдох эрсдэлтэй 40 иргэнд мөн 4 удаагийн эрх зүйн танхимын сургалтаар 391 иргэнд түгээсэн ба “Зүлэгт арванхоёрдугаар баг” цахим хуудсаар дамжуулан иргэдэд хууль тогтоомжийг сурталчлан ажилласны үр дүнд иргэдийн хандалт нэмэгдсэн. Түүнчлэн багт шилжин | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ирсэн 64 өрхийн гишүүдэд хотын дүрмийн талаар бэлтгэсэн гарын авлагыг түгээж, сурталчилж ажилласан. Нийт 18 төрлийн постер, гарын авлага, сургалт сурталчилгааны материал бэлтгэн боловсруулж, 495 иргэнд түгээсэн байна. | | |
| 2. | **Арга хэмжээ 1.2** Багийн иргэдийн Нийтийн хурлын бэлтгэл ажлыг хангах, шийдвэр гаргах түвшинд залуучуудын оролцоог нэмэгдүүлэх *(АТТодорхойлолт 1.3 дахь заалт)* | Холбогдох хууль тогтоомжийн дагуу хурлын бэлтгэл ажлыг хангасан хувиар | 100 | 100 | Багийн иргэдийн Нийтийн хурал 2025.02.05-ны өдөр болон 2025.06.10, 2025.10.17-ны өдрүүдэд буюу нийт 3 удаа хуралдсан. Багийн иргэдийн Нийтийн хуралдааныг хуралдуулах бэлтгэл ажлыг хангах хүрээнд: Багийн иргэдийн Нийтийн хурлын зөвлөлийг хуралдуулах, хуралдааны товыг тогтоох, хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тогтоох, хуралдаанаас гарах баримт бичгийн төсөл бэлтгэх, мөн багийн иргэдийн Нийтийн хурал болох өдөр хурлын заал болон шаардагдах техник хэрэгслийг бэлтгэн хурлын зарыг иргэдэд тэгш, хүртээмжтэй хүргэх зэрэг хуралдаан зохион байгуулах ажлын бэлтгэлийг хангаж ажилласны үр дүнд багийн иргэдийн нийтийн хурал ирц хүчин төгөлдөр хуралдсан. | 2025.01.02 2025.11.28 | 100 |
| | | Хуралд оролцсон залуучуудын оролцооны хувиар | 20 | 25-аас доошгүй хувь | Багийн иргэдийн Нийтийн хурал 3 удаа хуралдсан. Үүнд 1-р улирлын хуралд нийт 189 иргэн оролцож, үүнээс 18-39 насны залуучууд 65 байсан ба хуралдаанд оролцсон иргэдийн 34.3 хувийг залуучууд эзэлсэн. 2-р улирлын хуралд нийт 57 иргэн оролцож, үүнээс 18-39 насны 14 залуус оролцсон ба хуралд оролцсон иргэдийн 24.5 хувийг залуучууд эзэлж байна. 3-р улирлын хуралд нийт 43 иргэн оролцож, үүнээс 18-39 насны 8 залуучууд оролцсон | | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | ба хуралд оролцсон иргэдийн 18.6 хувийг залуучууд тус тус эзэлж байна.<br>1, 2, 3 дугаар улиралд нийт 289 иргэн хуралдаанд оролцож, үүнээс 18-39 насны 87 нь залуучууд байсан ба хуралд оролцсон нийт иргэдийн 30.1 хувийг залуучууд эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад багийн иргэдийн Нийтийн хуралд оролцсон залуучуудын оролцоо 1.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Багийн ажлын алба болон хэсгийн ахлагчид багийн иргэдийн Нийтийн хурал хуралдах зарыг тэгш, хүртээмжтэй хүргэж ажилласны үр дүнд хуралдаанд оролцох залуучуудын оролцоо нэмэгдсэн зэрэг үр дүнтэй байна. | | |
| 3. | **Арга хэмжээ 1.3** Багийн Иргэдийн Нийтийн хурлын тэмдэглэл, тогтоол шийдвэрийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу хөтлөх *(АТТодорхойлолт 1.4 дэх заалт)* | Хурлаас гарсан тэмдэглэл, тогтоол Шийдвэрийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулсан хувиар | 100 | 100 | Багийн иргэдийн Нийтийн хурал нийт 3 удаа хуралдаж, иргэдээс гарсан санал, хурлын тогтоол шийдвэрүүд, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, зөвлөлийн хурлын тэмдэглэл, хуралдааны тэмдэглэл, ирцийн бүртгэл зэргийг улирал тус бүрд буюу 3 удаагийн хуралдааны дагуу дээрх холбогдох баримт бичгүүдийг албан хэрэг хөтлөлтийн стандартын дагуу боловсруулж, хугацаанд нь 100 хувийн гүйцэтгэлтэй Арвайхээр сумын ИТХ-ын мэргэжилтэн Н.Энхбадамд хүлээлгэн өгсөн. | 2025.01.02<br>2025.11.28 | 100 ✓ |
| 4. | **Арга хэмжээ 1.4.**Арвайхээр сумын 2026 оны ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, | Багийн сонгуулийн насны нийт иргэдээс цаасан маягтаар санал өгсөн иргэдийн хувиар | 10 | 15-аас доошгүй хувь | 2026 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналд багийн сонгуулийн насны 982 иргэнээс цаасан маягтаар 175 иргэн буюу 17.8 хувь нь санал өгсөн. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад багийн сонгуулийн насны иргэдийн тоо 56-аар буюу 5.7 хувиар, цаасан маягтаар санал өгсөн иргэдийн тоо | 2025.01.02<br>2025.11.28 | 100 ✓ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөтөлбөр, төсөл, арга хэмжээг холбогдох журмын дагуу зохион байгуулах | | | | 11-ээр буюу 6.7 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна. | | |
| | | Багийн сонгуулийн насны нийт иргэдээс цахимаар санал өгсөн иргэдийн хувиар | 0.05 | 10-аас доошгүй хувь 10%. 1,7% | 2026 оны ОНХС-ийн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний саналд багийн сонгуулийн насны 982 иргэнээс ОНХС-ийн санал авах саналын программд 2 иргэн буюу 0.20 хувь нь санал өгсөн ба бусад цахим сүлжээгээр 15 иргэн санал өгснөөр нийт сонгуулийн насны иргэдийн 1.7 хувь нь цахимаар санал илгээсэн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад цахимаар санал өгсөн иргэдийн тоо 9-өөр буюу 52.9 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа боловч 2025 онд ОНХСангийн цахимаар санал авах саналын программ санал илгээхэд алдаа зааж, нэвтрэх боломжгүй байсан ба санал авах хугацааны ихэнх хугацаанд ажиллахгүй байсан нь иргэдийн хувьд хүндрэлтэй байсан. | 2025.01.02 2025.11.28 | 100 (17) |
| | | ОНХС-ын төсөл, арга хэмжээг Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтын дагуу боловсруулж, ХЗА-д хугацаанд нь бүрэн хүлээлгэж өгсөн хувиар | 100 | - | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2026 онд хийгдэх ажлын хүрээнд цаасан маягт болон цахимаар нийт 192 иргэнээс ирүүлсэн саналыг нэгтгэхэд 16 арга хэмжээний урьдчилсан жагсаалт гарсныг багийн иргэдийн Нийтийн 2 дугаар улирлын хуралдаанаар эрэмбэлэн 13 арга хэмжээг баталж, хурлын тогтоол болон холбогдох баримт бичгүүд, мөн орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журамд зааснаар 1-7 дугаар хавсралтын дагуу боловсруулж хотын Захирагчийн албаны Хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэнд хугацаанд нь хүлээлгэн өгсөн. ОНХС-ийн программын иргэдийн санал болон иргэдийн Нийтийн хурлаас | 2025.01.02 2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталсан төслүүд гэсэн 2 цэсэнд товлосон хугацаанд иргэдийн санал болон баталсан төслүүдийг үнэн зөв шивж оруулсан. | | |
| 5. | **Арга хэмжээ 1.5.** Хэсгийн ахлагчдын ажлын тайлан, мэдээг сар бүр хүлээн авч, улирал бүрээр нэгтгэн ИТХ-д хүргүүлэх | Хүргүүлсэн тайлангийн тоогоор | 4 | 4 | Багийн 15 хэсгийн ахлагчдын ажлын тайлан мэдээг сар бүр тогтмол хүлээн авч улирал бүрээр нэгтгэн нийт 4 удаагийн тайланг Арвайхээр сумын ЗДТГазрын нягтлан бодогчид хугацаанд нь хүргүүлсэн.<br>Багийн 15 хэсгийн ахлагчдын тайлан мэдээг сар бүр тогтмол хүлээн авч нэгтгэн, дээд шатны байгууллагад уламжлан ажилласны үр дүнд иргэдийн санал хүсэлт, тулгамдаж буй асуудал /үер, усны асуудал болон үхэр малтай айл өрхийг аймгийн төвөөс гаргах, худаг усан сангийн тоог нэмэх, Баяжих хэсэгт хүүхдийн тоглоомын талбайтай болох, гэрэлтүүлэг нэмэх, эрчим хүчний уналттай хэсгүүд буюу Баяжих хэсгийн 1-39 дүгээр гудамж мөн Жаргалант хэсгийн 12-20 дугаар гудамж болон эрчим хүчний төсөлд хамрагдаагүй хэсгүүдэд ухаалаг тоолуур суурилуулах, мөн ОНХСангийн хөрөнгөөр 0.4 шугам татах, нохой устгал хийх/ зэргийг 100 хувь шийдвэрлэсэн.<br>-Багийн 15 хэсгийн ахлагчдыг идэвхжүүлэн багийн нутаг дэвсгэрт эргүүл хийн, эрсдэлтэй айл өрхүүд болон хүн их цугларч архидан согтуурч буй айл өрхүүдийг мэдээллэх мөн аливаа зөрчил, мэдээллийг багийн ажлын алба болон багийн хэсгийн байцаагч нарт мэдэгдэж гарсан зөрчил бүрд арга хэмжээ авч ажилласны үр дүнд 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар гэмт хэрэг өмнөх оны мөн үетэй харьцуулахад өссөн үзүүлэлтгүй байна. | 2025.01.02<br>2025.11.28 | 100 ✓ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Түүнчлэн хэсгийн ахлагч нарыг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт болон бусад сургалт арга хэмжээнд оролцуулснаар бусдад эерэгээр нөлөөлөх нөлөөллийн ажил ахицтай байхын зэрэгцээ багийн ажлын алба 15 хэсгийн ахлагч нартай хамтран тэдгээрийн хариуцсан гудамж, тухайн хэсэгт оршин сууж буй иргэдэд аливаа зар, мэдээ, мэдээллийг хүргэх нь цаг хугацааны хувьд хурдан шуурхай бөгөөд цаг алдалгүй мэдээ, мэдээллийг иргэдэд дамжуулахад ахиц дэвшилт гарч байна. | | |
| 6. | **Арга хэмжээ 1.6.** Багийн хэмжээнд цэргийн бүртгэлийг зохион байгуулах, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд хариуцсан мэргэжилтэнд хүлээлгэн өгөх *АБТодорхойлолт 1.4 дэх заалт/* | Бүртгэлд хамрагдсан хувиар | 100 | - | Арвайхээр сумын 2025 оны цэргийн тоо бүртгэл 01 дүгээр сарын 08-ны өдрөөс 01 дүгээр сарын 17-ны өдрүүдэд зохион байгуулагдаж тус багийн 18-50 насны 292 иргэн хамрагдахаас бүгд хамрагдаж 100 хувьтай байна. Үүнд:<br>**1 дүгээр зэргийн бэлтгэл үүрэгтэн:** /Бэлтгэл байлдагч, түрүүч 110, төрийн цэрэгжсэн байгууллагын төрийн тусгай албан хаагч 4, цагдаа, тагнуул, ШШГазар, ШШАлбаны цэрэгт бүртгэлтэй мэргэжлээр алба хаасан төрийн тусгай албан хаагч 6, цэргийн алба хааж байгаа 2/<br>**2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн:** /Цэргийн албыг биеэр дүйцүүлэн хаасан 6, дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаасан 7, цэргийн жинхэнэ алба хаагаагүй 182, тайван цагт цэргийн албанд үл тэнцэгч 13/ | 2025.01.02<br>2025.11.28 | 100 ✓ |
| | | Хүргүүлсэн судалгаа, | 100 | - | Арвайхээр сумын ЗДТГазрын Хууль эрх зүйн мэргэжилтэнд I зэрэг, II зэрэг, ахлагч, байлдагч, түрүүч, II зэрэг нэгтгэл, нөөц, | 2025.01.02<br>2025.11.28 | 100 ✓ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тайлангийн хувиар | | | идэрчүүд, эрчүүдийн нэгдсэн, үл тэнцэгч буюу 0.7, Цэргийн алба хааж байгаа, статистик, боломж, буу, 1999 онд төрсөн залуус зэрэг нийт 15 төрлийн судалгаа, нэгтгэл мэдээг хугацаанд нь хүргүүлсэн. Мөн 2025 оны 1,2 дугаар ээлжийн цэрэг татлагад хамрагдсан нийт 58 иргэний жагсаалт, анкет, зарлан дуудах өгсөн тасалбар, мэдэгдэх хуудас зэргийг хүлээлгэн өгсөн. | | |
| 7. | **Арга хэмжээ 1.7.** Сумын дайчилгааны төлөвлөгөө, орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, орон нутгийн цэргийн отрядын хүн, техникийн оногдуулалтыг хийж бэлтгэл үүрэгтний бэлэн байдлыг хангах | Төлөвлөгөөний дагуу оногдуулалт хийсэн хувиар | 100 | - | Сумын дайчилгааны төлөвлөгөөний дагуу орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, орон нутгийн цэргийн отрядын хүн, техникийг оногдуултыг хийсэн.<br>Батлан хамгаалахын сайдын "Цэргийн бэлтгэл албаны сургалт явуулах тухай" 2025 н/01 дүгээр тушаалын дагуу цэргийн бэлтгэл албаны давтан бэлтгэх сургалтад Зэвсэгт хүчний 256 дугаар ангид 2 бэлтгэл үүрэгтнийг хамруулсан.<br>- Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор цэргийн бэлтгэл үүрэгтнүүдийн "Бид эх орны цэргүүд" чуулга уулзалт болж, Зүлэгт 12 дугаар багаас 2 бэлтгэл үүрэгтэн оролцсон. | 2025.01.02-2025.11-28 | 100 |
| | | Гаргасан судалгааны тоогоор | 1 | - | Оногдуулалт хийсний дагуу 72 техник, 39 хүний судалгааг цахим хэлбэрт оруулж Хууль эрх зүйн мэргэжилтэнд хүргүүлсэн.<br>Мөн дайчилгааны төлөвлөгөөний хүрээнд тодруулгыг хийж 7 төрлийн судалгааг Хууль эрх зүйн мэргэжилтэнд хүргүүлсэн. | | 100 |
| 8. | **Арга хэмжээ 1.8.** Багийн хэмжээнд цэрэг татлагын | Иргэдийн хамрагдалтын хувиар | 98 | 100 96,2. | 2025 оны I дүгээр ээлжийн цэрэг татлага 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулагдаж, I дүгээр ээлжийн цэрэг татлагад хамрагдах 18-25 насны 39, 1999 | 2025.01.02-2025.11.28 | 100 96,2 (58,7) |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах */АБТодорхойлолт 1.4 дэх заалт/* | | | | онд төрсөн буюу 26 насны 7, нийт 46 иргэний судалгааг гарган, зарлан дуудах хуудас хүргэн "Цэргийн албаны тухай" хууль сурталчлан ажилласны үр дүнд 42 цэрэг хамрагдаж, 4 цэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хамрагдаагүй ба цэргүүдийг 91.3 хувьтай хамруулж ажилласан. Үүнээс: Хилийн цэргийн 0131 дүгээр ангид-2, Дотоодын 805-р цэргийн ангид-2, нийт 4 иргэн цэргийн жинхэнэ албыг биеэр хааж байна. 2 дугаар ээлжийн буюу намрын цэрэг татлагад хавар ороогүй буюу хүндэтгэн үзэх шалтгааны улмаас цэрэг татлагад хамрагдаагүй 4, шилжин ирсэн 2, 18 насанд хүрсэн 6 нийт 12 цэргийн насны залуучууд хамрагдахаас 10 цэрэг хамрагдаж, 1 цэрэг тэнцэн Зэвсэгт хүчний 167 дугаар анги цэргийн жинхэнэ албыг биеэр хаахаар болсон ба 2 цэрэг өөр орон нутагт хамрагдахаар болсон. I, II дугаар ээлжийн цэрэг татлагад 18-25 насны нийт 54 цэрэг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж цэрэг татлагад бүрэн хамрагдахаас 52 цэрэг хамрагдаж, цэрэг татлагад хамрагдалт 96.2 хувьтай байна. Мөн I, II дугаар ээлжийн цэрэг татлагаар нийт 5 цэрэг цэргийн албанд тэнцэн, цэргийн жинхэнэ албыг биеэр хааж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад цэрэг татлагад хамрагдалтын хувь 12.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. | | |
| | | Цэргийн алба хааж буй иргэдийн ар гэрт олгох дэмжлэг, | 60 | 70 | 2025 оны I, II дугаар ээлжийн цэрэг татлагаар нийт 5 цэрэг цэргийн албанд тэнцэн, цэргийн жинхэнэ албыг биеэр хааж байна. Цэргийн алба хааж буй 5 цэргийн 3 дүүд эх үрсийн баярыг тохиолдуулан | 2025.01.02 2025.11.28 | 100 85,7 (51,5) |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | туслалцаанд хамруулсан өрхийн тоогоор | | | зохион байгуулсан арга хэмжээний хүрээнд бэлэг гардуулсан. | | |
| **Зорилт 2. "Багийн өрх, хүн амын статистикийн мэдээллийг зохих журмын дагуу нийтэд мэдээлж, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг ханган, удирдлагыг мэдээллээр хангах, тайлагнах"** | | | | | | | |
| 1. | **Арга хэмжээ 2.1.**Хүн ам, өрхийн мэдээллийн санг үнэн зөв хөтөлж, баяжилтыг тогтмол хийж, төрийн байгууллага, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж ажилласан байх *ІАБТодорхойлолт 2.1 дэх заалт/* | ХАӨМС-ын програмын алдааны тоогоор | 0 | 0 | Хүн ам, өрхийн мэдээллийн санд шилжин явсан 47 өрхийн 132 иргэн, нас барсан 6 иргэнийг хасалт хийн, шилжин ирсэн 65 өрхийн 168 иргэн, шинэ төрсөн 26 хүүхдийг нэмж, тогтмол баяжилт хийж ажилласнаар 2025 оны 11 сарын 28-ны байдлаар үндсэн 506 өрхийн 1737 хүн амтай болж, өмнөх оны мөн үетэй харьцуулахад өрхийн тоо 13-аар буюу 2.5 хувиар, хүн амын тоо 32-оор буюу 1.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.<br>Монгол Улсын Үндэсний Статистикийн газраас ирүүлсэн албан бичгийн дагуу хавсралтаар илгээсэн багийн 467 өрхийн байршил мөн хаягийн төрлийг ялган тэмдэглэж холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. Мөн Статистикийн газраас ирүүлсэн судалгааны дагуу нийт 90 өрхийн холбогдох утасны дугаарыг тодруулан холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн.<br>-ХАӨМСангийн мэдээлэл тодруулах программд 60 өрхийн гишүүдийн тодруулга болон 120 өрхийн мэдээллийг биечлэн тодруулга хийх аргаар иргэдтэй утсаар холбогдон мэдээллүүдийг программд оруулсан.<br>-ХАӨМСанд овог нэр солих, ургийн овог засах, регисртийн дугаар, хүйс, солих зэрэг тодруулгын хүрээнд багийн нэр сольсон 2 хүүхдийн мэдээллийг Төрийн сангийн | 2025.01.02-2025.11.28 | 100 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | мэргэжилтэн Л.Доржханд руу явуулсан. Өвөрхангай аймгийн Статистикийн газраас 2025 оны хүн ам, орон сууцны завсрын тооллогын тодруулга болон шинэ программын талаар зохион байгуулсан сургалтад хамрагдаж шинэ ХАӨМСанд баяжилт хийн, ХАӨМСангийн программыг алдаагүй үнэн зөв хөтлөхийн зэрэгцээ төрийн байгууллага, хэрэглэгчдийг мэдээллээр хангаж, судалгаа, мэдээг холбогдох мэргэжилтэнд товлосон хугацаанд хүргүүлсэн. | | |
| 2. | **Арга хэмжээ 2.2.** Багт шинээр баригдсан орон сууцны тооллогын мэдээг ОС1, ОС3 маягтаар гаргаж өгөх */АБТодорхойлолт 2.1 дэх заалт/* | Шинээр баригдсан орон сууцны мэдээллийг маягтын дагуу гаргаж өгсөн тоогоор | 2 | 2 | 2025 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар шинээр ашиглалтад орсон сууцны тусдаа байшингийн талаар буюу нийт 8 өрхийн мэдээллийг мөн 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар шинээр ашиглалтад орсон 7 сууцны тусдаа байшингийн мэдээллийг маягтын дагуу нийт 2 удаа Сумын ЗДТГ-ын Төрийн сангийн мэргэжилтэнд хүргүүлсэн.<br>2025 онд нийт 15 сууцны тусдаа байшин баригдсан. | 2025.01.02-2025.11.28 | 100 ✓ |
| 3. | **Арга хэмжээ 2.3.**Багт зохион байгуулсан ажил, арга хэмжээ болон бусад мэдээллийг олон нийтэд цахим хуудсанд сурталчлах *(АБТодорхойлолт 3.3 дахь заалт)* | Багийн цахим хуудсаар дамжуулан үйл ажиллагааны талаар мэдээ, мэдээлэл боловсруулж иргэдэд нээлттэй сурталчилгаа хийсэн тоогоор | 12 | 24 | Зүлэгт 12 дугаар багийн 1336 гишүүн, 1500 дагагчтай фейсбүүк цахим хуудсанд дараах мэдээ мэдээллийг бэлтгэн боловсруулж, иргэдэд нээлттэй сурталчилгаа хийж ажилласан. Үүнд:<br>- 12 дугаар багийн “Хүүхэд хамгааллын хамтарсан баг”-ийн 2025 оны тайлан мэдээлэл 1, эрүүл мэндтэй холбоотой 9, ном уншихын ач холбогдлын талаар 3, цаг агаарын мэдээ болон аюулт үзэгдлээс сэрэмжлүүлэх 36, гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой 39, цаг үеийн мэдээлэл болон | 2025.01.02-2025.11.28 | 100 ✓ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | бусад байгууллагын мэдээлэл 163, төрийн албан хаагчийн ёс зүйн зарчмын тухай бэлтгэсэн постер 1, "Хууль-Миний хамгаалалт" сэдэвт сургалт зохион байгуулсан тухай 1, хорт зуршил буюу тамхитай холбоотой 8, эрүүл амьдралын хэв маягтай, гэр бүлдээ хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг ашигладаг гэр бүлийн тухай контент бэлтгэсэн 1, багийн иргэдийн Нийтийн хурал хуралдсан тухай болон хурлын зар 5, охидын эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зохион байгуулсан арга хэмжээний тухай 1, шинэ худаг ашиглалтад орсон тухай 1, бүх нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах тухай 3, 3х3 сагсан бөмбөгийн талбай барьж байгаа тухай 1, нохойгоо уях тухай 5, хуванцар савнаас татгалзах тухай 6, "Хотын соёл-Хариуцлагатай иргэн" зорилтот жилийн хүрээнд зохион байгуулсан сургалт болон 8 өрх 32 ширхэг бургас тарьсан тухай мэдээлэл 1, Эхийн алдар одон гардан авах тухай 2, ОУ-ын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан "Хайр түгээе-Инээд бэлэглэе" арга хэмжээ зохион байгуулсан тухай болон спорт зааланд үнэгүй тоглуулах тухай 2, "Эртэч-Ахмад" арга хэмжээ зохион байгуулсан тухай 1, дайргын голд ахмадууд мод тарьсан тухай 1, Баяжих хэсгийн 1-39 дүгээр гудамж болон Жаргалант хэсгийн 12-20 дугаар гудамж буюу эрчим хүчний төсөлд хамрагдаагүй хэсгүүдэд ухаалаг тоолуур суурилуулж, мөн ОНХСангийн хөрөнгөөр 0.4 шугам татах ажил хийгдсэн тухай мэдээлэл 1, "Ашиг биш хариуцлагаа эрхэмлэе" аяны тухай 1, | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | "Ахмадаас суралцахуй" ахмадын баясах өдрийн арга хэмжээ зохион байгуулсан тухай 1, "Хууль ба-Амьдрал" сургалт зохион байгуулсан тухай 1, Угийн бичгийн сургалт зохион байгуулсан тухай 1, цэргийн бүртгэлийн тухай 4, "Эрүүл-Монгол хүн" үндэсний хөдөлгөөний хүрээнд зохион байгуулсан Шугаман бүжгийн улсын уралдаанд багийн Эгшиглэн хамтлаг оролцсон тухай мэдээлэл 1, болон багийн эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын 2025 оны төлөвлөгөөний дагуу 4 зорилтын хүрээнд 18 хууль тогтоомжийн талаар 44 постер бэлтгэн боловсруулж, багийн цахим хуудсаар дамжуулан иргэдэд түгээн, сурталчилж ажилласан. | | |
| 4. | **Арга хэмжээ 2.4.**Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн насны хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, хамран сургалтыг нэмэгдүүлэх, Боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй иргэдийг дүйцсэн хөтөлбөрт хамруулж, | Сургуулийн насны хүүхдийн хамран сургалтын хувиар | 100 | - | 1992 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийн 2 дугаар бүлгийн 16 дугаар зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар иргэн бүр сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно хэмээн заасны дагуу Ерөнхий боловсролын сургуулийн насны хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хамруулах, хамран сургалтыг нэмэгдүүлэх, боловсролын үйлчилгээнд хамрагдаж чадаагүй иргэдийг дүйцсэн хөтөлбөрт хамруулж, боловсрол эзэмшүүлэх зорилтын хүрээнд үр хүүхдэдээ боловсрол эзэмшүүлэх, хүүхдээ хэрхэн 1 дүгээр ангид бүртгүүлэх тухай зөвлөмжийг Зүлэгт 12 дугаар багт шилжин ирсэн иргэдэд болон хүүхдээ сургуульд сургахгүй байгаа эцэг, эх, асран хамгаалагч нарт тайлбарлан таниулснаар Ерөнхий боловсролын | 2025.01.02-2025.11.28 | 100 99,5 (59,7) |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | боловсрол эзэмшүүлэх | | | | сургуульд сурах багийн 6-17 насны нийт 491 хүүхдээс 489 хүүхэд сургуульд хамрагдаж, сургуулийн насны хүүхдийн хамран сургалт 99.5 хувьтай байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хамрагдалтын хувь ижил түвшинд байна.<br>Сургууль завсардсан дараах 2 хүүхэд:<br>-14 настай ба сургуульд сурах сонирхолгүй, хөдөө амьдардаг.<br>-15 настай ба бие муу учир сургуульд сурах боломжгүй.<br>Мөн Зүлэгт 12 дугаар багийн фейсбүүк цахим хуудсаар дамжуулан хүүхдээ хэрхэн нэгдүгээр ангид элсэн суралцуулах тухай постер нийт 3 удаа нийтэлж, иргэдэд түгээсэн. | | |
